



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

.... оны .. сарын .. өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Татварын хөнгөлөлт, илүү төлөлтийг хуулийн дагуу буцаан олгох данс хөтлөх түүнтэй холбоотой харилцааг зохицуулах журам"-ыг баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Гааль, Татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/185 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн сангийн газар /М.Батхуяг/, Татварын ерөнхий газар /Б.Заяабал/ нарт даалгасугай.

Ч.ХҮРЭЛБААТАР

ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ИЛҮҮ ТӨЛӨЛТИЙГ ХУУЛИЙН ДАГУУ БУЦААН ОЛГОХ, ДАНС ХӨТЛӨХ ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Татвар төлөгчийн холбогдох төсөвт төвлөрүүлсэн татварын орлогоос Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлд заасан татварын албаны шийдвэрээр татварын илүү төлөлтийг буцаан олгох, данс хөтлөх, буцаан олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Татварын алба татвар төлөгчийн илүү төлсөн татварыг Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д заасан дарааллын дагуу шийдвэрлэнэ. Хэрэв татвар төлөгч татварын өртэй бол хуульд заасан дарааллыг үл харгалзан татварын өрийг түрүүлж суутган тооцно.

1.3.Илүү төлсөн татварыг буцаан олгох харилцааг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулж болно.

1.4.Татварын алба нь татварын хөнгөлөлт, илүү төлөлтийг хуулийн дагуу буцаан олгох үйл ажиллагааг татварын төрлөөс хамааруулан ангилна.

Хоёр.Буцаан олголтын үйл ажиллагаа

2.1.Татварын алба нь буцаан олголтын үйл ажиллагааг татвар төлөгчийн хүсэлтийн дагуу болон татварын албаны шийдвэрээр дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1.буцаан олгох татварын хөнгөлөлт, илүү төлөлтийг баталгаажуулах хүсэлтийг татвар төлөгчөөс хүлээн авах;

2.1.2.татвар төлөгчийн илүү төлөлтийг баталгаажуулах хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

2.1.3.буцаан олговол зохих илүү төлөлтийн дүнг баталгаажуулсан үйл ажиллагааны үр дүнг татвар төлөгчид хүргүүлэх;

2.1.4.буцаан олголт авах хүсэлтийг татвар төлөгчөөс хүлээн авах;

2.1.5.буцаан олголт авах хүсэлтийг холбогдох төсвийн төрийн санд хүргүүлэх;

2.1.6.татвар төлөгчийн буцаан олголтыг татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх;

2.2.Буцаан олгох татварын хөнгөлөлт, илүү төлөлтийг баталгаажуулах хүсэлтийг татвар төлөгчөөс дараах байдлаар хүлээн авна:

2.2.1.хуулийн дагуу татварын тайлангаар тодорхойлогдох татварын хөнгөлөлтийн хүсэлтийг татвар төлөгч татварын тайлангаа илгээх үед;

2.2.2.цахим төлбөрийн баримтын системээс тодорхойлогдох татварын урамшууллын хүсэлтийг татварын системээр баталгаажуулснаар;

2.2.3.хяналт шалгалтын үр дүнгээр тодорхойлогдох татварын илүү төлөлтийн хүсэлтийг нөхөн ногдуулалтын актад үндэслэн;

2.2.4.эрх бүхий байгууллагын шийдвэрээр буцаан олгох татварын илүү төлөлтийн хүсэлтийг холбогдох шийдвэрийг үндэслэн.

2.3.Татвар төлөгчийн буцаан олголтын хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааг ажлын 60 хоногт хэрэгжүүлэх бөгөөд буцаан олгох татварын төрлөөс хамааруулан холбогдох хууль, журмаар зохицуулна.

2.4.Татвар төлөгчийн буцаан олголтын хүсэлтийг шийдвэрлэсэн бол хуулиар тогтоосон хугацаанд Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангаас татвар төлөгчид цахимаар, шуудангаар, биечлэн хүргүүлнэ.

2.5.Татвар төлөгч буцаан олговол зохих дүнг зөвшөөрөхгүй бол Татварын ерөнхий хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу гомдол гаргана.

2.6.Хэрэв татвар төлөгч нь татварын өртэй бол Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т заасны дагуу суутган тооцно.

2.7.Татвар төлөгч нь буцаан олголт авах хүсэлтийг татварын албанд ирүүлнэ.

2.8.Татварын алба нь буцаан олголт авах хүсэлтийг хянан үзэж, шаардлагатай баримт, буцаан олгох зориулалттай харилцах дансны санхүүжилтийн хүсэлтийн хамт холбогдох төсвийн төрийн санд хүргүүлнэ.

2.9.Төрийн сангийн буцаан олголт хийгдсэн холбогдох харилцах дансны зарлагын гүйлгээний мэдээллийг үндэслэн Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд татвар төлөгчийн буцаан олголтыг бүртгэнэ.

2.10.Буцаан олголтын бүртгэл хийгдсэн тухай бүр татвар төлөгчид холбогдох мэдээллийг цахимаар, шуудангаар, биечлэн хүргүүлнэ.

2.11.Татварын ерөнхий хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3-т зааснаар мэдэгдлийг гардуулсанд тооцно.

Гурав.Буцаан олголтын дансны төрөл, данс хөтлөх

3.1.Татварын алба нь татварын хөнгөлөлт, илүү төлөлтийг хуулийн дагуу буцаан олгох зориулалттай харилцах дансыг зөвхөн холбогдох төсвийн төрийн санд байршуулна.

3.2.Төрийн санд байрших татварын албаны буцаан олгох зориулалттай харилцах дансыг буцаан олголтын төрлөөр ангилна. Үүнд:

3.2.1.аж ахуйн нэгжийн орлогын албан татварын;

3.2.2.хувь хүний орлогын албан татварын;

3.2.3.нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн илүү төлсөн албан татварын;

3.2.4.дипломат төлөөлөгчийн болон консулын газрын албан ажлын болон тэдгээрт ажиллагсдын хувийн хэрэгцээнд зориулж, Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн албан татварын;

3.2.5.нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын;

3.2.6.маргаан таслах зөвлөлд татвар төлөгчийн нөхөн ногдуулалтын актад гаргасан гомдол гаргахад урьдчилан төлсөн татварын;

3.2.7.татварын буцаан олголтын актын баталгаажуулалтын;

3.2.8.шүүхийн шийдвэрээр буцаан олгох улсын тэмдэгтийн хураамжийн;

3.2.9.олон улсын гэрээний гэрээний дагуу ногдуулсан албан татварын;

3.2.10.бусад эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон илүү төлөлтийн.

3.3.Татварын алба нь буцаан олгох зориулалттай харилцах дансны санхүүжилтийн хүсэлтийг холбогдох төсвийн төрийн санд дараах шатлалаар хүргүүлнэ.

3.3.1.улсын төсвөөс буцаан олгох харилцах дансны санхүүжилтийн хүсэлтийг Татварын ерөнхий газрын холбогдох нэгж;

3.3.2.нийслэлийн төсвөөс буцаан олгох харилцах дансны санхүүжилтийн хүсэлтийг Нийслэлийн татварын газрын холбогдох нэгж;

3.3.3.аймаг, сумын төсвөөс буцаан олгох харилцах дансны санхүүжилтийн хүсэлтийг аймгийн татварын хэлтсийн холбогдох нэгж;

3.3.4.дүүргийн төсвөөс буцаан олгох харилцах дансны санхүүжилтийн хүсэлтийг дүүргийн татварын хэлтсийн холбогдох нэгж.

3.4.Татварын албаны хүргүүлсэн санхүүжилтийн хүсэлтийг хянан, шийдвэрлэх үүргийг холбогдох төсвийн төрийн сан хэрэгжүүлнэ.

3.5.Татвар төлөгчийн буцаан олгох үйл ажиллагааг татварын албанаас хүргүүлсэн хүсэлтийг хугацааны дарааллыг баримтлан хэрэгжүүлнэ.

3.6.Татварын албаны холбогдох нэгж нь буцаан олголтын харилцах дансны бүртгэлийг хөтлөн, улирал бүр холбогдох төсвийн төрийн сантай тооцоо нийлэн ажиллана.

3.7.Татвар төлөгчийн буцаан олголтыг татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, буцаан олголтын бүртгэлд хяналт тавих үйл ажиллагааг татвар төлөгчийн харьяалагдах татварын албаны холбогдох чиг үүрэг хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.

3.8.Татвар төлөгчийн буцаан олголтын үйл ажиллагааны ерөнхий хяналтыг Татварын ерөнхий газрын холбогдох чиг үүрэг хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.



Монголын Татварын Алба

ТӨСӨЛ

/2019.08.18-ны өдөр/

Сангийн Сайдын 2019 оны ... сарын ... -ны
өдрийн ... дугаар тушаалын ... хавсралт

Маягт...

БУЦААН ОЛГОХ ТАТВАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН МЭДЭГДЭЛ

Дугаар ...

Буцаан олголт баталгаажуулах хүсэлтийн мэдээлэл:

Нэр:	_____	Татварын төрөл:	_____
Регистрийн дугаар:	□□□□□□□□□□	Буцаан олголтот хамаарах хугацаа:	_____
Татварын төлөгчийн дугаар:	□□□□□□□□□□	Буцаан олголтын төрөл:	_____
Харьяалагдах татварын алба:	□□□ _____	Хүсэлт ирүүлсэн огноо:	□□□□□□□□

Буцаан олгох илүү үлдэгдлийн баталгаажуулалтын мэдээлэл:

Баталгаажуулалтын төрөл:	_____	Баталгаажуулсан шийдвэрийн дугаар:	_____
Баталгаажуулсан татварын алба:	□□□ _____	Баталгаажуулалт хийсэн этгээд:	_____
Хүсэлт ирүүлсэн огноо:	□□□□□□□□		

Баталгаажуулсан илүү үлдэгдэл татварын төрлөөр:

Татварын төрлийн код	Татварын төрлийн нэр	Баталгаажуулсан илүү үлдэгдлийн дүн
	Нийт дүн	

Тайлбар:

Буцаан олголтын төрөл:

- Дипломат, төлөлөгч, консулын газрын
- Олон улсын гэрээний хүрээний
- Татварын албаны үндэслэлгүйгээр хураасан мөнгөн хөрөнгийн
- Бусад татварын
- ХХОАТ-ын хөнгөлөлтийн
- Хувь хүний НӨАТ-ын урамшууллын
- НӨАТ суутгагчийн
- Шүүхийн шийдвэрийн УТХ-ийн

Баталгаажуулалтын төрөл:

- Татварын тайлангаар
- Шийдвэрээр-шийдвэрийн дугаар, огноо
- ХШ-аар-шийдвэрийн дугаар, огноо

